



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар

4/21

Модот

**“Үндсэн хуулийн өдөрт зориулсан спорт өдөрлөг”  
арга хэмжээ зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Шинэ үндсэн хууль батлагдсаны 33-н жилийн ойг тохиолдуулан сумын иргэд болон байгууллагуудыг биеийн тамир спортоор хичээллүүлэх, эрүүл мэндийг дэмжих, харилцан туршлага судлуулах, уялдаа холбоог сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтач эерэг уур амьсгалыг бий болгох, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор “ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДӨРТ ЗОРИУЛСАН СПОРТ ӨДӨРЛӨГ” -2025 арга хэмжээг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгуулллагатай хамтран зохион байгуулсугай.

2 Спорт өдөрлөгийн Засаг даргын Тамгын газар тусгай удирдамж боловсруулан батлуулж гүйцэтгэлийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (И.Найманцэцэг)-т даалгасугай..

3. Дээрхи арга хэмжээнд шаардагдах зардлыг Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас 1853500 ( Нэг сая найман зуун тавин гурван мянга таван зуун төгрөг)-ийг тооцож гаргахыг Санхүү албаны няглан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо )-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ